

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТТАЙ ИРГЭД ХАРИЛЦАН ВИЗГҮЙ
ЗОРЧИХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
МЕКСИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Мексикийн Нэгдсэн Улсын Засгийн газар (цаашид “Талууд”гэнэ),

Монгол, Мексикийн Засгийн газар болон ард түмний хоорондын найрамдлын халуун дотно харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэж буйг илэрхийлэн,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Мексикийн Нэгдсэн Улсын Засгийн газраас олгосон хүчин төгөлдөр дипломат буюу албан паспорт эзэмшигчид нь Монгол Улсын нутаг дэвсгэрт визгүй зорчиж болох бөгөөд орсноосоо хойш ер /90/ хоног хүртэл хугацаанд байх эрхтэй.

2 дугаар зүйл

Монгол Улсын Засгийн газраас олгосон хүчин төгөлдөр дипломат буюу албан паспорт эзэмшигчид нь Мексикийн Нэгдсэн Улсын нутаг дэвсгэрт визгүй зорчиж болох бөгөөд орсноосоо хойш ер /90/ хоног хүртэл хугацаанд байх эрхтэй.

3 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт дурдсан паспорт эзэмшигчид албан ажил, аялал жуулчлалын зорилгоор буюу гуравдагч орон руу дамжин өнгөрөхөөр Монгол буюу Мексикт визгүй зорчиж болно.

Дээр дурдсанаас өөр зорилгоор зорчих паспорт эзэмшигч нь улс бүрийн дотоодын хууль тогтоомжийн шаардлагын дагуу холбогдох байгууллагаас олгодог шилжин суурших тодорхой, статусыг урьдчилан авна.

4 дүгээр зүйл

Монгол Улс болон Мексикийн Нэгдсэн Улсад суугаа Элчин сайдын яам, эсхүл Консулын газарт томилогдсон албан тушаалтан хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт ороход виз шаардагдахгүй, гэхдээ тухайн улсад орсноос хойш гуч /30/ хоногийн дотор Гадаад хэргийн яамны холбогдох зөвшөөрлийг авах ёстой; энэ нөхцөлд хүлээн авагч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу шилжин суурьших тодорхойлолт, статусыг холбогдох байгууллага олгоно.

Энэ журам нь дээр дурдсан дипломат буюу албан паспорт эзэмшигчдийн гэр бүлийн хүмүүст мөн хамаарна.

5 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт дурдсан паспорт эзэмшигчид нь цагаачлалын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн аливаа боомтоор дипломат болон

албан паспорт эзэмшигчдэд хамаарах аюулгүй байдал, цагаачлал, гааль, эрүүл мэндийн болон бусад хууль тогтоомжид зааснаас өөр хязгаарлалтгүйгээр Монгол болон Мексикт орж, гарч болно.

6 дугаар зүйл

Хоёр Талын эрх бүхий байгууллагууд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос гуч (30) хоногийн өмнө 1 дүгээр зүйлд заасан зорчих баримт бичгүүдийн загварыг хэрэглэх болон тэдгээрийн шинж тэмдгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийн хамт дипломат шугамаар солилцоно.

Хүчин төгөлдөр ашиглаж буй паспорт өөрчлөгдвөл хоёр Талын эрх бүхий байгууллагад шинэ паспортын загварыг хэрэглэхээс гуч (30) хоногийн өмнө дипломат шугамаар солилцоно.

7 дугаар зүйл

Хоёр Талын эрх бүхий байгууллагууд өөрийн улсын нутаг дэвсгэрт гадаадын хүмүүс орох, байх болон гарахтай холбогдсон хууль тогтоомжид орсон аливаа өөрчлөлтийг дипломат шугамаар шуурхай мэдээлнэ.

8 дугаар зүйл

Хоёр Тал тааламжгүй этгээд (non grata) хэмээн үзсэн этгээдийг өөрийн нутаг дэвсгэрт хүлээн авахаас татгалзах эрхтэй байна.

9 дүгээр зүйл

Тал бүр нийгмийн хэв журам, аюулгүй байдал, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болох ба нэг Тал нь ийнхүү түр зогсоосон буюу зогсоосноо сунгасан тухайгаа нөгөө Талд дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

10 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр түүнд гарын үсэг зурснаас хойш жар (60) хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд хугацаагүй үйлчилнэ. Аль нэг Тал нөгөө Талдаа гуч (30) хоногийн өмнө дипломат шугамаар бичгээр мэдэгдэж түүнийг хүчингүй болгож болно.

2001 оны арван нэгдүгээр сарын 09-ний өдөр Нью-Йорк хотноо монгол, испани, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Орчуулгын зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**МЕКСИКИЙН НЭГДСЭН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг